

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ 08 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

1. Үндсэн үйл ажиллагаа

Газрын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. “Мэнд цэцэн өрхийн эрүүл мэндийн төв”, “Мөнхийн гэгээ өрхийн эрүүл мэндийн төв”, “Орон нутгийн өмчийн газар”, “Жаргалант сумын Хоршоо хөгжлүүлэх сан”, “Баян-Өндөр сумын Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр” зэрэг байгууллагуудын 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж байна.

“Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв”, “Учралт баяр өрхийн эрүүл мэндийн төв”-ийн 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дуусгаж тус байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт зөрчил, дүгнэлтийг танилцуулж ажиллалаа.

Архивын улсын үзлэг шалгалт болохтой холбоотой ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.

Нэгдсэн менежментийн тогтолцоонд магадлан аудит 2025 оны 09 дүгээр сард ирэхтэй холбоотой Чанарын баг стандартын сайжруулалт, баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлуудыг хийж байна.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР